

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
даргын 2011 оны наймдугаар сарын 04-ны
өдрийн 1/3 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт


Залуучуудын аварга шалгаруулах боксын
тэмцээний шүүгчдийн бүрэлдэхүүн

№	Шүүгчдийн овог, нэр	Байгууллага	Гүйцэтгэх үүрэг	Зэрэг
1.	Ц.Цэрэнням		Ерөнхий шүүгч	У/Ш
2.	Т.Амаржаргал		Нарийн бичгийн дарга	У/Ш
3.	Б.Баярсайхан		Шүүгч	У/Ш
4.	Т.Цогтбаяр		Шүүгч	У/Ш
5.	Ц.Нямжав		Шүүгч	У/Ш
6.	Б.Ганзориг		Шүүгч	У/Ш
7.	С.Ганбат		Шүүгч	У/Ш
8.	Ц.Жамсран		Шүүгч	У/Ш
9.	П.Билэг		Шүүгч	У/Ш
10.	Ж.Отгон		Шүүгч	У/Ш
11.	Ө.Цэрэнмядаг		Шүүгч	У/Ш
12.	А.Баасандорж		Шүүгч	У/Ш
13.	Э.Мөнхбат		Шүүгч	У/Ш
14.	М.Батчулуун		Шүүгч	У/Ш

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын 2011 оны наймдугаар сарын 04-ны өдрийн 135 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Залуучуудын аварга шалгаруулах боксын тэмцээний төсөв

№	Зардлын нэр	Дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 1-р байр 12 x 8000 төг = 96.000 төг 2-р байр 12 x 6000 төг = 72.000 төг 3-р байр 24 x 5000 төг = 120.000 төг	288.000
2.	Шүүгчдийн ажлын хөлс: /14 хүн x 2 хоног x 15000 төг/	420.000
3.	Медалийн үнэ	240.000
4.	Заал талбайн хөлс	150.000
НИЙТ ДҮН:		1.098.000



Монгол Улсын Ууган Гавьяат тамирчин, Ази тивийн хошой аварга, дасгалжуулагч багш Х.Алтанхуягийн нэрэмжит залуучуудын Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээний заавар

Нэг. Тэмцээний зорилго

Монгол улсад өсвөр, залуу үеийнхэнд бие бялдрын өв тэгш хүмүүжил олгох, боксын спортыг таниулан сурталчлах, тэдний дунд өргөнөөр дэлгэрүүлэн хөгжүүлэх, Олимп, тив, дэлхийн аварга, тамирчид дасгалжуулагчдын залгамж халааг бэлтгэх, ирээдүйд Олимп, тив дэлхийн, аварга шалгаруулах тэмцээнүүдэд Монгол улсаа төлөөлөн оролцох шилдэг тамирчдыг төрүүлэн гаргах, сонгон шалгаруулахад оршино.

Хоёр. Тэмцээн болох газар, хугацаа

2011.08.16-19-ний өдрүүдэд Улаанбаатар хотод Спортын Төв Ордны "А" зааланд болно.

Гурав. Тэмцээн явагдах журам, насны ангилал, жингүүд

Тэмцээнийг МОБХ-ноос томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн АИБА-гийн шинэчлэгдсэн дүрмийн дагуу удирдан явуулна. Жин тус бүрд багуудаас нэг хүн байх ёстой боловч хүнийхээ тоонд багтаан 1-ээс илүүгүй жинд 2 тамирчин орж болно. Тамирчин бүр иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, эрүүл мэндийн дэвтэр, АИБА-гийн дэвтэртэй байх зайлшгүй шаардлагатай.

Хөвгүүд: 16-17 насны(1994-1995 онд төрсөн)

Жин: 42, 44, 46, 49, 52, 56, 60, 64, 69 кг

Тулаан явагдах хугацаа: 3 үе x 2 минут

Охид: 16-17 насны(1994-1995 онд төрсөн)

Жин: 44-46, 48-51 кг

Тулаан явагдах хугацаа: 3 үе x 2 минут

Дөрөв. Техникийн зөвлөгөөн

2011.08.15-ны өдөр Спортын Төв ордонд МОБХ-ны 212 тоот өрөөнд 15.00 цагт болно.

Тав. Шагнал урамшуулал

Жин тус бүрт эхний 3 байр эзэлсэн тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнана. Багийн дүнг Олимпын системээр дүгнэж цом алт, мөнгө, хүрэл медаль өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнана. Мөн шилдэг тамирчин, шилдэг дасгалжуулагчийн тусгай шагнал олгоно.

Зургаа. Санхүү

Тэмцээнд оролцох баг тамирчдын тээврийн болон байр хоолны зардлыг үндсэн байгууллага нь хариуцна.

Долоо. Бусад

Баг хариуцсан дасгалжуулагч нь тамирчидаа эмнэлэгийн гүнзгийрүүлсэн үзлэгт бүрэн хамруулж, мэдүүлэг болон АИБА-гийн дэвтэр дээр нь зайлшгүй тэмдэглүүлсэн байх ёстой. Эмэгтэй боксчид жирэмсэн биш гэдгээ нотолсон эмнэлэгийн баталгаат бичигтэй байна. Дасгалжуулагчид жингийн үзлэгийн үед болон тэмцээний үед тамирчидтайгаа ямагт хамт байж рингэнд биечлэн авч гарах ба хувцаслалт, сахилга дэг журмыг бүрэн хариуцана. Тэмцээнд боксчны бээлий, толгойны хамгаалалт, гарч буй булангийн өнгөтэй заавал адил байна. Тэмцээний үед сахилга дэг журам зөрчсөн дасгалжуулагчдын тамирчидыг тэмцээнээс хасаж холбогдох байгууллага руу нь албан бичиг явуулах, цаашид тодорхой хугацаагаар багаар нь тэмцээнд оролцох эрхийг нь хасах хүртэл арга хэмжээ авна.

НИЙЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

МОНГОЛЫН ОЛИМПЫН БОКСЫН ХОЛБОО



109

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Залуучуудын аварга шалгаруулах боксын тэмцээнийг зохион байгуулах тухай

Нийслэлийн Засаг даргын 2009-2012 оны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх хөтөлбөр, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

Нэг. Улаанбаатар хотын 2011 оны залуучуудын аварга шалгаруулах боксын тэмцээнийг 2011 оны 08 дугаар сарын 16-19-ны өдрүүдэд Спортын Төв ордны "А" зааланд зохион байгуулсугай.

Хоёр. Тэмцээний төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.098.000 /нэг сая ерин найман мянга/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын спортын арга хэмжээний зардлаас гаргахыг ня-бо Ж.Цэдэнсодномд зөвшөөрсүгэй.

Дөрөв. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн Б.Батсайханд үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНБОЛД